



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/297

Алтай хот


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 2022 оны "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 21 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай" 2018 оны зарлиг, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Үндэсний бичиг үсгийн баярыг угтан зохион байгуулж буй Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах Улсын ХҮИ уралдааны зардалд шаардагдах 1,458,000 (нэг сая дөрвөн зуун тавин найман мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хяналт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж ажиглахыг Засаг даргын орлогч, Хэлний бодлогын салбар зөвлөл (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР